

БАНКНЫ САЛБАРЫН ТОЙМ-3

Банкны салбарын шинэчлэлтэй холбоотойгоор системийн нөлөө бүхий банкууд хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд хувьцаагаа арилжаалж эхлээд байгаа билээ. Үүнтэй холбоотойгоор бидний зүгээс банкны салбарын гол үзүүлэлтүүдийн талаар 7 хоног бүр нэгтгэн харилцагч, хөрөнгө оруулагч нартаа хүргэж буй. Энэ 7 хоногт бид банкны ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН БАГЦ-ын талаар мэдээлэл бэлтгэлээ.

НИЙТ ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН ҮЛДЭГДЭЛ

2022 оны жилийн эцсийн байдлаар банкуудын нийт зээлийн үлдэгдэл 22.0 их наяд төгрөг байв.

Үүний 5.1% буюу 1.1 их наяд төгрөгтэй тэнцэх хэмжээний зээл нь 1-90 хоногийн хугацаа хэтрэлттэй буюу “Хугацаа хэтэрсэн” ангилалд, 10.1% буюу 2.0 их наяд төгрөгтэй тэнцэх хэмжээний зээл нь 90-ээс дээш хоногийн хугацаа хэтрэлттэй буюу “Чанаргүй” зээлийн ангилалд байна.


Сүүлийн 5-н жилийн хугацаанд банкуудын чанаргүй зээлийн нийт зээлийн багцад эзлэх хувь нь 2020 онд хамгийн дээд хэмжээндээ буюу 13.3%-д хүрч байсан бол 2022 оны жилийн эцсийн байдлаар 10.1%-д хүрч 2018 оноос хойш хамгийн доод цэгтээ хүрчээ.

Их наяд төгрөг



Аж ахуйн нэгж, байгууллагуудын ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН ҮЛДЭГДЭЛ

Их наяд төгрөг



2022 оны жилийн эцсийн байдлаар нийт зээлийн үлдэгдлийн 46.1% буюу 10.1 их наяд төгрөгтэй тэнцэх хэмжээний зээл нь хувийн байгууллагуудад олгосон зээл байна. Үүнээс 14.9% буюу 1.5 их наяд төгрөгтэй тэнцэх хэмжээний зээл нь “Чанаргүй” зээлийн ангилалд байна.

Хувийн байгууллагуудад олгосон чанаргүй зээлийн үлдэгдлийг салбараар нь ангилж харвал хамгийн өндөр нь 24.2% буюу 366 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний зээл нь уул уурхай,

олборлолтын салбарт олгосон зээлийн үлдэгдэл байна. Үүний дараагаар 22.9% буюу 346 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний зээл нь барилгын салбарт олгосон зээлийн үлдэгдэл байна.


Эх сурвалж: Монголбанк

Иргэдэд олгосон ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН ҮЛДЭГДЭЛ


2022 оны жилийн эцсийн байдлаар банкуудын нийт зээлийн үлдэгдлийн 52.5% буюу 11.6 их наяд төгрөгтэй тэнцэх хэмжээний зээлийг иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл эзэлж байна.

Үүний 4.3% буюу 501 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний зээл нь “Чанаргүй” зээлийн ангилалд орсон байна. ААН, байгууллагуудад олгосон зээлтэй харьцуулахад иргэдэд олгосон зээлийн чанаргүй зээлийн хувь харьцангуй бага байгаа нь харагдаж байна.

Иргэдэд олгосон хэрэглээний зээлийн үлдэгдлийг 2022 оны жилийн эцсийн байдлаар ангилж харвал автомашины болон картын зээлийн чанаргүй зээлийн хувь харьцангуй өндөр буюу 15.5% болон 13.6% байгаа бол тэтгэврийн зээл, малчны зээл болон хадгаламж барьцаалсан зээлүүдийн чанаргүй зээлийн хувь харьцангуй бага буюу 0.1-0.6% байна.



Системийн нөлөө бүхий банкуудын ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН ҮЛДЭГДЭЛ



*2022 оны 3-р улиралын гүйцэтгэл

2022 оны жилийн эцсийн байдлаар системийн нөлөө бүхий 5 банкуудын чанаргүй зээлийн үлдэгдлийн нийт зээлийн үлдэгдэлд эзлэх хувийг харьцуулан харвал Худалдаа Хөгжлийн банкны чанаргүй зээлийн хувь харьцангуй өндөр буюу 22.4% байсан бол Төрийн банкны чанаргүй зээлийн хувь салбарын дундажтай ойролцоо буюу 11.3% байна. Үүнтэй харьцуулахад Голомт банк, Хаан банк, Хасбанкуудын чанаргүй зээлийн хувь салбарын дунджаас доогуур буюу харьцангуй бага хувьтай гарсан байна.